



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2010 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 324

Улаанбаатар хот

Г “Энхсар инвест ББСБ” ХХК-ийн Ү  
банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Энхсар инвест ББСБ” ХХК-ийн гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Холбогдох өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг холбогдох баримтын хамт 2010 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Энхсар инвест ББСБ” ХХК /Т.Саран/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал /-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН